Эх, хүүхдийн эрүүл мэнд
/2020 оны 6 сарын байдлаар/

Төрөлт

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 6 сарын байдлаар нийт 813 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 төрөлтөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 79.0% /643/ нь төрсөн байна. Кесар хагалгаагаа төрөлтийн /177/21,8 хувийг эзэлж байна

Хүүхдийн эрүүл мэнд

2020 оны 6 сард Аймгийн хэмжээнд 815 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 7 хүүхдээр буюу 0.8 хувиар өссөн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 53.0 хувь нь эрэгтэй, 47.0 хувь нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 2.3/19/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 99.3 байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 6 сарын байдлаар нялхасын эндэгдлийн 7 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөнд 8.6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11.2 промилоор буурсан ба улсын дундажаас доогуур байна. Улсын дундаж 12,0 промил байна. Нялхасын эндэгдэл Өмнөдэлгэр-1, Баянмөнх-1, АНЭ-5 эндсэн байна. Гэрийн эндэгдэл /2/28.5%-ийг эзэлж байна.
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 42.8 хувь нь эрэгтэй хүүхэд байна.
5 хүртэлх насны эндэгдэл 1000 амьд төрөлтөд 13.5 байна. Улсын дундаж 14,6 промил байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан

2020 оны эхний 6 сарын байдлаар 5 хүртэлх насандаа эндсэн 7 тохиолдол бүртгэгдсэн байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл осол гэмтэл-5, уушигны хатгалгаа-3, нярайн амьсгалын гачаал-1, төрөлхийн гажиг-1, нярайн тархины хчмрал-1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Жирэмсний хяналт

Жирэмсний хяналтанд шинээр 874 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 89.1 хувь нь эхний 3 сартайд, 9.8 хувь нь 4-6 сартайд, 7 дээш сартайд 1,1 хувь нь хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 96.3 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 1.3 хувь нь цус багадалттай байна.
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 600 буюу 68.6 хувь нь эерэг-16, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 598 буюу 68,4 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 852 буюу 97,4 хувь, эерэг-11, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 97.3 хувь тус тус хамрагдсан байна.

Нас баралтын үзүүлэлтүүд

2020 оны эхний 6 сарын байдлаар нийт нас баралтын 155 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 26 тохиолдлоор буурсан ба 59.3 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 2.02 байна.

Нийт нас баралтын 9.1 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 21.5 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 22,5 хувийг эзэлж байна.
Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 22 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 14,1 хувийг эзэлж байна. 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 2,83 байна.

2020 оны 6 сарын байдлаар хорт хавдарын хяналтанд 550 хүн бүртгэгдсэнээс хорт хавдараар нас барсан 35 тохиолдол бүртгэгдсэн байна.

2020 оны 6 сарын байдлаар артери гипертензийн эрт илрүүлэг үзлэгт нийт 7548 /37.4/ хүн хамрагдаж 56.8 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 65 байна. Чихрийн шижингээр онош батлагдсан 11 тохиолдол байна.

Хөх эрт илрүүлэг үзлэгт 29.8 хувь, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 19,1 хувийн хамралттай пап шинжилгээгээр 25 эерэг тохиолдол бүртгэгдсэн байна.

Амбулатори ,стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

Аймгийн хэмжээнд 2019 оны 6 сарын байдлаар эмнэлэгт 9078 хүн хэвтэн эмчлүүлж нийт 65289 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7,2 байна.

Амбулаторит эхний 6 сарын байдлаар 166426 үзлэг хийгдсэний 25.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 47.6 хувийг өвчний учир амбулаторит, 13,9 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, үлдэх 12.9 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна.

Халдварт бус өвчлөл 29968 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 4803 өвчлөлөөр буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 6 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөлийн нийт 684 тохиолдол бүртгэгдсэнээс 66,9 эрэгтэй, 33,1 эмэгтэй байна. Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаанд: бүх төрлийн уналт /213/31,1%, зам тээврийн осол /156/22,8%, амьгүй механик хүчин өртөх /123/17,9%, түлэгдэлт /57/8,3%, хүчирхийлэл /47/6,8% тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 6 сарын байдлаар 14095 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 16,8% нь алсын дуудлага эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил байна.

10000 хүн амд ногдох халдварт өвчин
2020 оны эхний 6 сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2020 оны 6 сарын байдлаар 228 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 29.7 ногдож байна. /Улсын дундаж 37.1 / Улс аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

Халдварт өвчин бүтэц



Нийт халдварт өвчнүүд дотор БЗДХ /136/ 59.6 хувь, сүрьеэ /69/ 30.2 хувь, салхинцэцэг /18/ 7.8 хувь, гар хөл амны өвчин 2 тохиолдол гарч тус тус бүртгэгдсэн байна.
БЗДХ-ын дотор тэмбүү /62/, трихомониз /45/, гонококт халдвар /29/ тохиолдол бүртгэгдэж урьд оноос 48 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.